

## АГУУЛГА

<b>НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>3</b>
1.1. Төслийн талаарх мэдээлэл.....	3
1.2.Төслийн байршил.....	3
1.3.Орд ашиглах тусгай зөвшөөрөл .....	7
1.4.Ордын нөөц .....	7
1.5.Уурхайн нээлт ба ашиглах дараалал.....	8
1.6.Уурхайн ашиглах хугацаа ба жилийн хүчин чадал .....	9
1.7.Уурхайн ажиллах горим.....	9
1.8.Уурхайн ашиглалтын технологи .....	9
1.9. Драг буюу хөвөгч төхөөрөмж ашиглан олборлох, баяжуулах технологи .....	10
1.10.Тунаах нуур ба хаягдлын аж ахуй.....	10
1.11.Дэд бүтэц .....	10
<b>ХОЁР.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>12</b>
<b>ГУРАВ.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДРХОЙЛОЛТ .....</b>	<b>14</b>
3.1. Газрын хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл .....	14
3.2. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл .....	14
3.3. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	14
3.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл .....	14
3.5. Ургамлан нөмрөг .....	15
3.6. Амьтан .....	15
3.7. Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	15
<b>ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....</b>	<b>16</b>
<b>ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>18</b>
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
5.2.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	23
5.3.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	24
5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө .....	25
5.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	25
5.6.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	25
5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	26
5.8.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	28
5.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	31

5.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах.....	32
5.11. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	33
<b>ДҮГНЭЛТ.....</b>	<b>34</b>
<b>АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>34</b>

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл .....	3
Хүснэгт 2. Төслийн солбилцол .....	3
Хүснэгт 3. Ордны нөөцийн тооцооны үр дүнгийн нэгдсэн хүснэгт .....	8
Хүснэгт 4. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт .....	9
Хүснэгт 5. Уурхайн ажлын горим .....	9
Хүснэгт 6. Ашиглалтын систем.....	9
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	18
Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	23
Хүснэгт 9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	24
Хүснэгт 10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	25
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	26
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	28
Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	31
Хүснэгт 14. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	32
Хүснэгт 15. 2023 оны БОМТ-ний нийт зардал .....	33

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Хадат толгойн хойд үргэлжлэл дэх алтны шороон ордыг ил аргаар .....	6
ашиглах ” төслийн байршлын зураг .....	6

### НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

#### 1.1. Төслийн талаарх мэдээлэл

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Эйч эс эйч эс” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		9019083069
3	Уурхайн нэр		“Хадат толгойн ордын хойд үргэлжлэл дэх алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төсөл
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Төв
5		Сум/Дүүрэг	Заамар
6	Ашигт малтмалын төрөл		Алт
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-021529
8	Ашиглалт эхэлсэн огноо		2023 он
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
10		Сум/Дүүрэг	Баянзүрх
11		Баг/Хороо	
12		Гудамж/Байр	Жамъяанжүгийн гудамж
13		Хаяг	19 Вэн жоу зочид буудал
14		тоот	816 тоот
15		Шуудангийн хайрцаг	
16		Утас	
17		Факс	-
18		Гар утас	976-99075239
19		Электрон шуудан	hshsmongolia@gmail.com
20	Вэб хуудас		
21	Захирлын хаяг	Нэр	Захирал Б.Билгүүнзаяа
22		Утас	
23		Факс	
24		Гар утас	976-99150150
25		Электрон шуудан	

#### 1.2. Төслийн байршил

Төв аймгийн Заамар сум Мандалын хоолой, Баасангийн хоолой нэртэй газарт оршино. Нийт 1654.22 га талбайтай.


Хүснэгт 2. Төслийн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	104	37	45.99	48	38	10.83
2	104	35	41.46	48	38	10.83
3	104	35	41.43	48	38	10.77
4	104	35	40.78	48	38	9.83
5	104	35	39.97	48	38	8.87
6	104	35	38.9	48	38	7.79
7	104	35	38.92	48	38	6.8

8	104	35	38.88	48	38	6.32
9	104	35	38.84	48	38	5.79
10	104	35	38.66	48	38	5
11	104	35	38.49	48	38	4.56
12	104	35	38.28	48	38	4.02
13	104	35	38.09	48	38	3.7
14	104	35	37.67	48	38	2.97
15	104	35	37.38	48	38	2.57
16	104	35	36.93	48	38	1.97
17	104	35	35.75	48	38	0.76
18	104	35	35.75	48	38	0.76
19	104	35	35.75	48	38	0.75
20	104	35	35.64	48	38	0.67
21	104	35	34.74	48	37	59.94
22	104	35	33.59	48	37	59.18
23	104	35	32.11	48	37	58.43
24	104	35	30.55	48	37	57.84
25	104	35	29.96	48	37	57.68
26	104	35	28.74	48	37	57.35
27	104	35	26.03	48	37	56.82
28	104	35	23.9	48	37	56.32
29	104	35	23.01	48	37	56.11
30	104	35	21.76	48	37	55.9
31	104	35	21.28	48	37	55.82
32	104	35	20.96	48	37	55.79
33	104	35	19.08	48	37	55.62
34	104	35	16.71	48	37	55.64
35	104	35	15.97	48	37	55.7
36	104	35	14.73	48	37	55.81
37	104	35	12.68	48	37	56.19
38	104	35	12.54	48	37	56.23
39	104	35	10.91	48	37	56.74
40	104	35	10.51	48	37	56.91
41	104	35	10.01	48	37	57.13
42	104	35	9.26	48	37	57.51
43	104	35	9.2	48	37	57.54
44	104	35	9.2	48	37	57.54
45	104	35	9.2	48	37	57.54
46	104	35	9.13	48	37	57.58
47	104	35	7.95	48	37	58.34
48	104	35	6.72	48	37	59.41
49	104	35	5.65	48	38	0.68
50	104	35	4.64	48	38	2.21
51	104	35	4.08	48	38	2.26
52	104	35	2.86	48	38	2.37

53	104	35	1.27	48	38	2.41
54	104	35	0.65	48	38	2.43
55	104	34	59.7	48	38	2.4
56	104	34	57.65	48	38	2.35
57	104	34	55.63	48	38	2.25
58	104	34	54.11	48	38	2.17
59	104	34	50.73	48	38	1.87
60	104	34	47.6	48	38	1.4
61	104	34	47.07	48	38	1.28
62	104	34	46.41	48	38	1.13
63	104	34	42.39	48	38	0.09
64	104	34	38.78	48	37	59.16
65	104	34	37.49	48	37	58.92
66	104	34	36.75	48	37	58.78
67	104	34	36.26	48	37	58.72
68	104	34	35.3	48	37	58.61
69	104	34	33.33	48	37	58.52
70	104	34	33.19	48	37	58.51
71	104	34	33.19	48	37	58.51
72	104	34	31.28	48	37	58.59
73	104	34	29.14	48	37	58.86
74	104	34	27.95	48	37	59.1
75	104	34	26.66	48	37	59.34
76	104	34	26.05	48	37	59.34
77	104	34	20.19	48	37	56.94
78	104	34	19.29	48	37	56.63
79	104	34	17.39	48	37	55.97
80	104	34	16.44	48	37	55.7
81	104	34	15.78	48	37	55.51
82	104	34	14.41	48	37	55.19
83	104	34	14.02	48	37	55.11
84	104	34	12.51	48	37	54.81
85	104	34	11.32	48	37	54.63
86	104	34	10.29	48	37	54.46
87	104	34	8.85	48	37	54.3
88	104	34	7.09	48	37	54.11
89	104	34	6.1	48	37	54.05
90	104	34	5.07	48	37	53.98
91	104	34	2.83	48	37	53.96
92	104	34	2.76	48	37	53.96
93	104	33	57.92	48	37	54.04
94	104	33	54.04	48	37	53.94
95	104	33	51.06	48	37	53.76
96	104	33	47.69	48	37	53.32
97	104	33	40.35	48	37	51.96

98	104	33	40.14	48	37	51.84
99	104	33	39.58	48	37	51.51
100	104	33	38.42	48	37	50.66
101	104	33	37.82	48	37	50.08
102	104	33	37.69	48	37	49.95
103	104	33	36.07	48	37	48.2
104	104	33	35.89	48	37	48
105	104	33	35.73	48	37	47.84
106	104	33	34.76	48	37	46.92
107	104	33	32.99	48	37	45.45
108	104	33	11.99	48	37	39.85
109	104	35	11.98	48	37	39.85
110	104	35	50.76	48	37	6.85
111	104	33	50.76	48	37	6.85
112	104	33	50.76	48	36	31.85
113	104	35	0.98	48	36	31.85
114	104	35	0.98	48	35	50.86
115	104	37	45.99	48	35	50.86



**Зураг 1. “Хадат толгойн хойд үргэлжлэл дэх алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн байршлын зураг**

### 1.3. Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Төв аймгийн Заамар, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших Мандалын хоолой, Басангийн хоолой нэртэй хайгуулын XV-006371 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбай нь анх “Жэй Кэй Эм Кэй” ХХК -ийн эзэмшилд байсан ба тус хайгуулын талбайд 2006-2008 онд Гэртийн дэнж, Хадат толгой нэртэй хэсгүүдэд хайгуулын ажлыг явуулж хайгуулын ажлаар тогтоогдсон нөөцийг улсын бүртгэлд бүртгүүлсэн, мөн тухайн онд нөөц бодсон талбайд “Хадат толгой” нэртэй MV-015066 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг авч, улмаар 2010 оноос олборлолтын үйл ажиллагаа явуулсан байдаг.

Улмаар 2009 онд “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хууль батлагдах үед тус Мандалын хоолой, Басангийн хоолой нэртэй хайгуулын XV-006371 тоот тусгай зөвшөөрлийн талбай нь энэ хуулийн хүрээнд цуцлагдсан бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс шүүхэд нэхэмжлэл гаргаж, улмаар захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу АМГТГ-аас уг хайгуулын XV-006371 тусгай зөвшөөрлийг “Жи Кэй Эм Кэй” ХХК -ийн нэр дээр буцаан шинээр сэргээж, хайгуулын тусгай зөвшөөрлийн шинэ дугаарыг XV-021045 болгосон байна.

Тус хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг 2019 оны 01-р сарын 30-ны өдөр АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 7/646 тоот тушаалаар “Жи Кэй Эм Кэй” ХХК-ийн эзэмшлээс “Хао Шен” ХХК -ний эзэмшилд шилжүүлсэн бөгөөд 2020 оны 02-р сарын 12-ны өдөр аж ахуй нэгжийн албан ёсны нэрээ өөрчилж “Эйч Эс Эйч Эс” ХХК болсон байна.

### 1.4. Ордын нөөц

Туул голын татмын ордын, Хадат толгой хэсгийн хойд үргэлжлэлд гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлаар дээд ба доод гэсэн хоёр давхарга ялгасан бөгөөд уг давхаргуудад бодитой болон боломжтой зэрэглэлээр нийт 36 хэсэгшилд хуваагдаж байна.

Дээд давхаргад бодитой “В” зэрэглэлээр хучаас хөрсний хэмжээ 3136.47 мян.м<sup>3</sup>, алттай элсний хэмжээ 255.59 мян.м<sup>3</sup>, дундаж агуулга 263 мг/м<sup>3</sup> алтны нөөц химийн цэврээр

59.28 кг, жигнэсэн дундажаар хучаас хөрсний зузаан 16.84 м алттай элсний давхаргын зузаан 1.37м, боломжтой “С” зэрэглэлээр хучаас хөрсний хэмжээ 1080.55 мян.м<sup>3</sup>, алттай элсний хэмжээ 99.02 мян.м<sup>3</sup>, дундаж агуулга 381 мг/м<sup>3</sup>, алтны нөөц химийн цэврээр 33.25 кг, жигнэсэн дундажаар хучаас хөрсний зузаан 15.78м, алттай элсний давхаргын зузаан 1.45м, дээд давхаргын нийт нөөц В+С зэрэглэлээр хучаас хөрсний хэмжээ 4217.0 мян.м<sup>3</sup>, алттай элсний хэмжээ 354.6 мян.м<sup>3</sup>, дундаж агуулга 296 мг/м<sup>3</sup> алтны нөөц химийн цэврээр 92.53 кг, жигнэсэн дундажаар хучаас хөрсний зузаан 16.55 м, алттай элсний давхаргын дундаж зузаан 1.39 м болж байна.

Доод давхаргад бодитой “В” зэрэглэлээр хучаас хөрсний хэмжээ 15068.1 мян.м<sup>3</sup>, алттай элсний хэмжээ 803.6 мян.м<sup>3</sup>, дундаж агуулга 333 мг/м<sup>3</sup> алтны нөөц химийн цэврээр 235.83 кг, жигнэсэн дундажаар хучаас хөрсний зузаан 22.56 м алттай элсний давхаргын зузаан 1.20 м, боломжтой “С” зэрэглэлээр хучаас хөрсний хэмжээ 4380.9 мян.м<sup>3</sup>, алттай элсний хэмжээ 221.3 мян.м<sup>3</sup>, дундаж агуулга 367 мг/м<sup>3</sup>, алтны нөөц химийн цэврээр 71.63 кг, жигнэсэн дундажаар хучаас хөрсний зузаан 26.13 м, алттай элсний давхаргын зузаан 1.32 м, доод давхаргын нийт нөөц В+С зэрэглэлээр хучаас хөрсний хэмжээ 19449.0 мян.м<sup>3</sup>, алттай элсний хэмжээ 1025.0 мян.м<sup>3</sup>, дундаж агуулга 340 мг/м<sup>3</sup> алтны нөөц химийн цэврээр 307.47 кг, жигнэсэн дундажаар хучаас хөрсний зузаан 23.28 м, алттай элсний давхаргын

дундаж зузаан 1.23 м болж байна. Геологи хайгуулын ажлаар тогтоогдсон хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд дахь нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгтээр дор үзүүлэв.

**Хүснэгт 3. Ордны нөөцийн тооцооны үр дүнгийн нэгдсэн хүснэгт**

Нөөцийн зэрэглэл, Блокын Дугаар	Хөрсний зузаан, м	Давхаргын зузаан, м	Дунд аж	Блокын талбай мян.м2	Хөрсний хэмжэ мя н.м	Алттай элсний хэмжээ,	Нөөц, кг шлихээр	Нөөц, кг цэврээр
<b>ДЭЭД ДАВХАРГА</b>								
<b>В</b>	15.07	0.93	243	15.42	232.	14.4	3.	<b>3.08</b>
<b>В</b>	17.45	1.88	334	68.43	1194.	128.3	42.8	<b>37.7</b>
<b>В</b>	15.6	1.1	201	15.63	243.	17.2	3.46	<b>3.04</b>
<b>В</b>	15.73	1.73	239	12.21	192.	21.2	5.07	<b>4.46</b>
<b>В</b>	15.43	1.09	125	28.2	435.	30.6	3.83	<b>3.37</b>
<b>В</b>	17.6	1.07	203	12.34	217.	13.2	2.67	<b>2.35</b>
<b>В</b>	18.3	0.9	206	19.6	358.	17.6	3.63	<b>3.</b>
<b>В</b>	18.2	0.8	145	6.72	122.	5.	0.78	<b>0.69</b>
<b>В</b>	18.2	1	203	7.74	140.	7.	1.57	<b>1.38</b>
<b>Н</b>	<b>16.84</b>	<b>1.37</b>	<b>263</b>	<b>186.29</b>	<b>3136.</b>	<b>255.6</b>	<b>67.29</b>	<b>59.28</b>
<b>С</b>	15	1	282	2	29.9	2	0.56	<b>0.</b>
<b>С</b>	15.64	1.75	427	45.26	707.	7	33.77	<b>29.75</b>
<b>С</b>	15.73	1.2	213	10.09	158.	12.1	2.58	<b>2.28</b>
<b>С</b>	16	0.4	150	7.62	121.	3	0.46	<b>0.</b>
<b>С</b>	18.8	1.2	140	0.12	2	0.	0.02	<b>0.02</b>
<b>С</b>	17.6	0.8	129	3.41	60.1	2.	0.35	<b>0.31</b>
<b>Н</b>	<b>15.78</b>	<b>1.45</b>	<b>381</b>	<b>68.49</b>	<b>1080.</b>	<b>9</b>	<b>37.74</b>	<b>33.25</b>
<b>Нийт Вв+Св</b>	<b>16.55</b>	<b>1.39</b>	<b>296</b>	<b>254.78</b>	<b>4217</b>	<b>354.6</b>	<b>105.03</b>	<b>92.53</b>
<b>ДООД ДАВХАРГА</b>								
<b>В</b>	14.25	1.55	354	30.77	438.	47.7	16.88	<b>14.87</b>
<b>В</b>	14.11	1.24	319	44.35	625.	54.8	17.47	<b>15.39</b>
<b>В</b>	14.19	1.01	351	72.63	1030.	73.4	25.76	<b>22.7</b>
<b>В</b>	15.66	1.09	344	73.63	1153.	80.6	27.73	<b>24.43</b>
<b>В</b>	20.57	1.62	348	103.37	2126	167.1	58.23	<b>51.3</b>
<b>В</b>	23.22	1.29	286	83.68	1943.	107.6	30.76	<b>27.1</b>
<b>В</b>	<b>26.17</b>	<b>0.94</b>	<b>222</b>	<b>52.66</b>	<b>1378.</b>	<b>49.5</b>	<b>11.01</b>	<b>9.</b>

**1.5. Уурхайн нээлт ба ашиглах дараалал**

Алттай элсний давхаргыг олборлон баяжуулах, угаах тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг тасралтгүй хангах нөхцлийг бүрдүүлэх ёстой. Иймээс эхний жил бэлтгэл ажилтай зэрэгцэж 14-16 шугам хоорондох магадласан В<sup>1</sup> үйлдвэрлэлийн 13, 14, 15 блокуудын хөрсийг хуулж, тус блокуудын элсний давхаргыг зөөвөрлөн угаах төхөөрөмжийн дэргэд овоолго үүсгэж түүний доорхи доод давхаргын В<sup>1</sup>-16 нөөцийн блокын хөрсийг хуулж элсний давхаргыг нээж, элсний давхаргыг драгаар олборлон баяжуулах, мөн дараагийн жилүүдэд энэ маягаар зүүнээс баруун чиглэлд уулын ажлын ахиж явахаар жил бүрийн төлөвлөлтийг хийж, уулын ажлын календар төлөвлөгөөг зохиолоо.



### 1.6. Уурхайн ашиглах хугацаа ба жилийн хүчин чадал

Ил уурхайн хил хүрэн дэх, эдийн засгийн хувьд үр ашигтай “Магадласан В<sup>1</sup> үйлдвэрлэл” -ийн нөөцийн тооцоогоор төслийн хугацаанд ашиглах нийт алт агуулсан элсний нөөц 943.5 мян.м<sup>3</sup>, нийт хуулах хөрсний хэмжээ 9539.1 мян.м<sup>3</sup>, дундаж агуулга 282 мг/м<sup>3</sup>, хөрс хуулалтын коэффициент 10.1 м<sup>3</sup>/м<sup>3</sup>, алтны нөөц шлихээр 266.1 кг, нийт ил уурхайн хүрэн дэх уулын цулын хэмжээ 10.48 сая.м<sup>3</sup> болж байна.

**Хүснэгт 4. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт**

Үзүүлэлт	Хэм. нэгж	Ашиглалтын жилүүд					
		1	2	3	4	5	Нийт
Нийт хуулах хөрсний	мян.м <sup>3</sup>	2314.3	2172.1	1734.7	1696.7	1621.4	9539.1
хөрсний гадаад овоолго	мян.м <sup>3</sup>	565	45	35	20	0	665
хөрсний дотоод овоолго	мян.м <sup>3</sup>	1749.3	2127.1	1699.7	1676.7	1621.4	8874.1
Элс олборлолт	мян.м <sup>3</sup>	149.75	266.52	157.62	178.73	190.91	943.5
дээд давхаргын элс	мян.м <sup>3</sup>	25	80.46	157.62	88.28	0	351.4
доод давхаргын элс	мян.м <sup>3</sup>	124.75	186.06	0	90.45	190.91	592.2
Хөрс хуулалтын	м <sup>3</sup> /м <sup>3</sup>	15.45	8.15	11.01	9.49	8.49	10.1
Дундаж агуулга	мг/м <sup>3</sup>	232.02	262.21	290.97	335.55	291.33	282
дээд давхаргын агуулга	мг/м <sup>3</sup>	159.27	153.43	290.97	382.49	0	273
доод давхаргын агуулга	мг/м <sup>3</sup>	246.6	309.25	0	289.73	291.33	287
Металлын хэмжээ	кг	34.75	69.88	45.86	59.97	55.62	266.1
дээд давхаргын металл	кг	3.98	12.35	45.86	33.77	0	96
доод давхаргын металл	кг	30.76	57.54	0	26.21	55.62	170.1
Металлын хэмжээ /х.ц/	кг	30.61	61.57	40.4	52.84	49	234.4
дээд давхаргын металл	кг	3.51	10.88	40.4	29.75	0	84.5
доод давхаргын металл	кг	27.1	50.69	0	23.09	49	149.9
Уурхайн олборлолтын үйл	2	83.8	102	106	139	137	567.8

### 1.7. Уурхайн ажиллах горим

**Хүснэгт 5. Уурхайн ажлын горим**

№	Үзүүлэлт	Жилд
1	Жилд ажиллах боломжит хоног	210 хон
2	Цаг агаарын хүндрэлээс шалтгаалан сул зогсолт хийх хоног	5 хон
3	Засвар үйлчилгээ, техникийн саатлаас болж сул зогсох хоног	10 хон
4	Жилд ажиллах ажлын хоног	195 хон
5	Уурхайн жил бүрийн эхэнд хийх бэлтгэл ажлын хоног	10 хон
6	Хөрс хуулалтын ажил гүйцэтгэх хоног	185 хон
7	Элс олборлох, угаах боломжит хоног	150 хон
8	Хоногт ажиллах ээлжийн тоо	2 ээлж
9	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	12 цаг

### 1.8. Уурхайн ашиглалтын технологи

**Хүснэгт 6. Ашиглалтын систем**

Тоног төхөөрөмж	Үндсэн ажил	Технологийн процесс
Экскаватор	Хөрс хуулалт	- Утгаж ачих (мөрөгцөгөөс ухах)
Автосамосвал		- Ачиж тээвэрлэх (хөрсний овоолго)

Экскаватор	Дээд давхаргын элс олборлолт	- Утгаж ачих (мөрөгцөгөөс ухах)
Автосамосвал		- Ачиж тээвэрлэх ( агуулахын овоолго)
Угаах төхөөрөмж	Доод давхаргын элс олборлолт	- Угаах-ангилах-ялгах-боловсруулах
Драг		- Утгах, олборлох
аг		- Угаах-ангилах-ялгах-боловсруулах

Төсөл хэргэжүүлэгчийн зүгээс тус шороон ордын доод давхаргыг БНХАУ-д үйлдвэрлэсэн JH-150 маркын драгаар алттай элсийг олборлохоор тоног төхөөрөмжийн судалгаа хийж хөрөнгө оруулалтаар авахаар төлөвлөөд байгаа бөгөөд элсний давхаргыг драгаар ашиглахаар тооцсон. Драгаар ашиглах аргын гол давуу тал нь өндөр бүтээл, тасралтгүй ажиллагаа, удирдлагыг төвлөрүүлэх боломж зэрэгт оршдог.

### 1.9. Драг буюу хөвөгч төхөөрөмж ашиглан олборлох, баяжуулах технологи

Төсөл хэргэжүүлэгчийн зүгээс тус шороон ордод ашиглахаар сонгож авсан JH-150 маркын Драгийн ашигт давхаргыг олборлох гүн нь уснаас доош 8-12 м, цагт 150 м<sup>3</sup>, хоногт 2000-3000 м<sup>3</sup> элс угаана. Драгийн нийт урт нь 31.0 м, өргөн нь 8.0 м, өндөр нь уснаас дээш 1.5м, элс олборлож хутгах 45 шанагатай, минутанд 0-22 шанага элс олборлох хүчин чадалтай. Драг нь мөргөцөгт канатан татлагаар хөдөлнө. Өөр дээрээ 380В хүчдэлээр хангах цахилгаан үүсгүүртэй ба элс олборлож, баяжуулах буюу яглах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

### 1.10. Тунаах нуур ба хаягдлын аж ахуй

Хаягдалын сан нь 3 хэсгээс бүрдэнэ үүнд 1-рт шлам хүлээж авах буюу шүүж тунаах хэсэг, 2-рт тунаах нуур буюу булингтай усыг тунаах, цэвэршүүлэх хэсэг, 3-рт цэвэршүүлсэн эргэлтийн буюу цэвэр усны нуур бүхий усан сан байна. Тус ордоос угаах төхөөрөмжөөр элс угаан баяжуулах хүчин чадал 25.0-157.7 мян.м<sup>3</sup> ашиглалтын нийт хугацаанд 351.4мян.м<sup>3</sup> байна. Үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэх тусам хэрэглэх усны хэмжээ болон алдагдах усны хэмжээ мөн адил нэмэгддэг иймээс технологийн зориулалтар хэрэглэх цэвэр усны хэмжээг багасгах усны алдагдалын хэмжээг бууруулах зорилгоор технологийн усыг цэвэршүүлж дахин эргүүлж ашигладаг.

Технологийн усыг уурхайд шүүрлээр орж ирх /хоногт 1612м<sup>3</sup>/ усаар хангах аа нийт баяжуулалтын технологийн хэрэгцээний усны 30% нь уурших, эфилль гаальтай хаягдах зэргээр алдагдах бөгөөд технологийн усны 70% -ийг цэвэршүүлж эргүүлэн ашиглана. Иймээс баяжуулах хэсгийн ойролцоо хамгийн багадаа 7-10 хоногийн хугацаанд угаах баяжуулах төхөөрөмжийг технологийн усаар хангах хэмжээний цэвэр усны нуур, мөн

7-10 хоног угаасан элс буюу шламыг хадгалах, шламын усыг шүүж өтгөрүүлэх багтаамж бүхий тунаах нуур байгуулна. Эхний хэсэг нь угаах төхөөрөмжнөөс орж ирж буй шламын усыг шүүж угаагдсан элс болох эфилийг тунааж утгуурт ачигчаар авч зайлуулах зориулалттай. Дараагын усан сан буюу тунаах нуур нь булинга усыг шүүж цэвэршүүлэх цэвэр усны нуурт оруулах эргэлтийн усыг хангах үүрэгтэй юм. Эхний даланд тунасан эфилль болон угаах хэсгээс гарсан гаалийг алт агуулсан элс тээвэрлэн ирсэн автосамосвалд ачиж хөрсний дотоод овоолгын дор эргүүлэн байрлуулна.

### 1.11. Дэд бүтэц

#### 1.11.1. Усан хангамж

Технологийн усны 70-80%-ийг эргэлтийн усаар хангана. Уурхайн унд ахуйн усан хангамжыг дээрхи 2010 онд өрөмдөж гаргасан гүний худгаас хангахаар тооцоолсон. Элс угаан баяжуулах Драг бүхий скрубберын технологийн шат дамжлагаас гарч байгаа усыг

баяжуулах хэсэгт дахин ашиглах бөгөөд үүнийг эргэлтийн ус гэх ба эргэлтийн усыг өндөр хувьтайгаар ашигласнаар байгалийн эх үүсвэрээс авах цэвэр усны зарцуулалтыг бууруулна. Ил уурхайд ус шавхалт, зайлуулалтын ажлыг байнга хийж байх шаардлагатай.

Иймд дээрх гидрогеологийн судалгаагаа зэрэгт тулгуурлан уурхайд орж ирэх усыг ил уурхай хажуу ёроолыг дагуулан тодорхой налуутайгаар суваг ухаж уурхайд орж ирх усыг тусгай бэлтгэсэн зумпфэнд хуримтлуулах аргыг хэрэглэх нь тохиромжтой юм.

Зумпфэнд хуримтлагдсан усыг ил уурхайн гадна талд тусгайлан бэлдсэн ус хуримтлуулж, цэвэршүүлэх нуурт насосоор шахаж, шавхалтын усыг цэвэршүүлэх бөгөөд уг нуураас буцаан цэвэршигдэж, шүүгдсэн усыг мөн насосоор шахаж зайлуулна.

#### **1.11.2. Цахилгаан хангамж**

Уг алтны шороон ордын уурхайн цахилгаан хангамжийн эх үүсвэр нь төсөл хэрэгжүүлэгчийн төлөвлөснөөр дизель цахилгаан үүсгүүрээр цахилгааны хэрэглээг хангахаар төсөлд тусгасан.

Уурхайн ашиглалтын хугацаа бага, техник тоног төхөөрөмжүүд нь ихэвчлэн дизель түлшээр ажиллах тул 150кВа-ийн чадалтай дизель цахилгаан үүсгүүр авч уурхайн тосгон болон угаах хэсэг, усны насос зэргийг цахилгаанаар хангана. Ил уурхайн гэрэлтүүлэг болон уурхайн шүүрлийн ус зайлуулах насос нь энэхүү дизель станцаас хол зайтай байх тул эдгээрийг цахилгаан хэрэглээг 50кВа чадалтай дизель станцаар тусад нь хангана.

#### **1.11.3. Хүний нөөц**

Тус алтны шороон ордыг ашиглах ашиглалтын нийт хугацаанд 90 хүнийг тогтмол ажлын байраар хангана. Ажилчдын хотхонд тогтмол 60 хүн ажиллах бөгөөд хоногт хоёр ээлжээр ажиллана.

## ХОЁР.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Геологийн тогтоц:** Судалгааны талбай нь тектоник структурын байршлаараа Хойт Хэнтийн захын өргөгдлийн баруун хэсэгт, түүнийг Хойт Монголын атираат мужийн Тариат-Сэлэнгийн өргөгдлөөс заагласан Баянголын гүний хагарлын бүсийн зүүн өмнөд захад оршино. Энэ нутагт үүсэж тархсан чулуулгийн нас, тэдгээрийн харилцан байршил, структурын онцлогийг үндэслэн каледоны (түрүү, жинхэнэ каледона) герциний атираат, мезозойн цаг үеийн идэвхжлийн, кайнозойн шинэхэн тектоник хөдөлгөөний структурын ярус гэж ялган геологийн хөгжлийн түүхийг тодорхойлсон байдаг.

**Геоморфологи:** Судалгааны талбайн гадаргуу дээд палеозойн эринд нийтдээ өргөгдөж, уулархаг хэлбэрт шилжсэн бөгөөд өнөөгийн ерөнхий суурь мезозойн эринд тавигдсан байна. Заамарын болон Хар бухын хотгор, туул голын хөндийнүүд олон төрлийн хэлбэртэй татам дэнжүүд илрэх бөгөөд янз бүрийн агуулгатай үнэт металлын шороон ордуудыг үүсгэнэ. Кайнозойн эринд элэгдэл, зөөгдөл, хуримтлал эрчимтэй явагдаж, жинхэнэ тектоник хөдөлгөөний нөлөөгөөр уулс хоорондын хотгор, томоохон голуудын хөндийн хэмжээнд тасрал эвдрэл үүсч дээш өргөгдөх, доог суух үйл ажиллагаа хэдэн удаа давтагджээ. Үүний үр дүнд голын хөндийн доош суусан хэсгүүд, эртний ухагдсан гүн хотсуудад плиоцены улаан өнгийн шавар, алт агуулсан шаравтар өнгийн хурдсууд хадгалагдан үлджээ.

**Уур амьсгал:** Тус бүс нутаг нь Монгол орны эрс тэс уур амьсгалтай. Өвөл 1-р сард -37<sup>0</sup> хүрдэг ба 9-р сарын сүүл 10-р сарын эхээр сэрүүсдэг. 3-р сараас хаврын дулааны урь орж 4-р сараас цас хайлж дуусдаг. Жилийн дундаж хур тунадас 360 мм унах ба 85% нь зуны улиралд буудаг. Олон жилийн цэвдэг байхгүй. Өвөл хөрс нь 2-2.5 м гүн хөлддөг байна. Салхи нь голчлон хойноос. Баруун хойноос 3.5 м/сек салхины жилийн дундаж хурдтай ба хавар зарим тохиолдолд 20 м/сек хүрдэг.

**Усан хангамж:** Төсөл хэрэгжих талбайд хамгийн ойр орших гадаргын усны илэрц нь Туул гол бөгөөд уурхайн нь Туул голын голдирлын дагуу байрлана. Туул голын сав газарт хамаарагдах ба голын сүлжээний нягтшил харьцангуй бага буюу 0.1-0.2 км/км<sup>2</sup>, нийлбэр урсац нь 1-2 л/с км<sup>2</sup> бага, хур борооны үерийн хамгийн их урсац 10-30 мм, шар усны үерийн хамгийн их урсац 4-20 мм бөгөөд зуны хур бороо болон хаврын шар ус, зуны хур борооны усаар үерлэдэг шинж чанартай. Хур тунадасны жилийн нийлбэр нь 200-250 мм боловч нийлбэр ууршилт нь 200 мм-ээс дээш байна. Зуны улиралд усны гадаргаас уурших ууршилт 500-700 мм ба голын тэжээлийн горимын хувьд газрын доорх ус 20%, цасны ус 25%, хур борооны ус 55% байна.

**Гидрогеологи:** Судлагдаж буй талбай нь гидрогеологийн мужлалын хувьд Хэнтийн гидрогеологийн бүсийн Туул голын ай савын доод хэсэгт хамаарна. Судалгааны районы хүрээнд голын хөндийн дөрөвдөгчийн аллювийн хурдасны усажсан давхарга болон тунамал-хувирмал болон интрузив чулуулгийн ан цавын усажсан бүрдэл ялгагдана. Ан цавын усажсан бүрдэл нь голын хөндийн усажсан давхаргын гадаад тэжээлийн муж болох ба алтны тархсан талбайд ил илрэхгүй дөрөвдөгчийн хурдсаар хучигдсаж голын хөндийн усжсан давхаргын ус үл нэвтрүүлэх тулгуур нь болж өгөх онцлогтой юм.

Голын хөндийн аллювийн хурдасны ус агуулагч чулуулаг нь элс, элсэнцэрээр чигжигдсэн хайрга, хайргархаг хурдас бөгөөд заримдаа валун агуулна. Газрын доорх ус газрын гадаргуугийн хэлбэр дүрсээс хамаарч харилцан адилгүй гүнээс илэрдэг. Голын татам буюу гол руу ойртох тусам бага гүнээс буюу 1.5-2 м-ээс голоос холдох тусам гүн нь аажмаар нэмэгдэж 8-19 м-т хүрнэ.

Хадат алтны ордын талбайд газрын доорх ус 6-19 м-ийн гүнээс илрэн тогтсон юм. Газрын доорх усны түвшингийн хэлбэлзэл тэжээлээс шууд хамааралтай. Тэжээлийн гол эх үүсвэр нь агаарын хур тунадас болон голын усны шүүрэлт юм. Өөрөөр хэлбэл, голын ус ба газрын доорх ус шууд гидравлик холбоотой оршино. Татмын захын хэсэгт гидрогеологийн массивын далд алсын шүүрэлтээс тэжээл авах байна.

**Хөрс, ургамал:** Төсөл хэрэгжих талбайн хувьд уулын хар хүрэн хөрс, хар хүрэн хөрс, нугын хөрс зонхилон тархсан байна.

Заамарын бүс нутгийн нам уулын хажуу, налуугаар шивээт хялганат, хазаар өвст, агьт, алаг өвст хээр тархахаас гадна уулын оройн хэсгээр ботуульт хээр зонхилно. Уулс хоорондын хөндийгөөр хялганат, хиагт, алаг өвст, харганат хээрүүд зонхилон тархдаг.

Тал хөндийн төв хэсгээр үетэн-хялганат болон хялгана-агь-үетэнт хуурай хээрүүд элбэг таарна. Хааяа уулын ар хажуугийн чийглэг судгуудыг дагаж хөвөн хусан торлогон ширэнгэ тохиолдоно. Туул голын татмын хоёр талын өргөн хөндийгөөр жижиг навчит харгана бүхий агь-хялганат хээр, мөн үхэр харгана, бүхий харгана-хазаар өвст хээр элбэг тархдаг.

**Амьтны аймаг:** Тус бүс нутаг нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол-Төвдийн муж, Монголын ойт хээрийн дэд мужид хамаарагдах Монгол дагуурын хээрийн тойрог, Заамарын уулын районд хамаарна.

Энэ бүс нутгийн амьтны аймагт нийт 11 багийн 280 гаруй зүйл шавж, 1 зүйл хоёр нутагтан, 1 зүйл мөлхөгч, 13 зүйл загас, 140 зүйл шувуу, 39 зүйлийн хөхтөн амьтан бүртгэгдэв.

**Нийгэм эдийн засаг:** Төв аймгийн Заамар сум нь УБ хотоос 180 км өөрийн аймгаас 225 км алслагдан оршдог бөгөөд Төв аймгийн Угтаал, Цээл, Лүн сум Булган аймгийн Баяннуур, Бүрэгхангай, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумтай хиллэж нийт 281,207 га нутаг дэвсгэрийг эзэлдэг.

## ГУРАВ.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДРХОЙЛОЛТ

### 3.1. Газрын хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас хөрс хуулах, элс олборлох ажлын үед газрын хэвлийд хамгийн их сөрөг нөлөөлөл учруулахаар байна. Элс угаах болон, дэд бүтцийн байгууламжийн үйл ажиллагаанаас газрын гадаргад үзүүлэх нөлөөлөл байх боловч газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага юм.

### 3.2. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Ашиглалтын нийт хугацаанд шимт хөрс хуулалт, овоолго үүсгэх үйл ажиллагаанаас 87.0 тн тоос, хаягдал чулуулаг болон элс ачих үйл ажиллагаанаас 254.1 тн тоос, хаягдлын овоолгын гадаргаас 933.6 тн, элс буулгах талбайгаас 90.8 тн тоос, уурхайн дотоод тээвэрлэлтээс 4099 тн тоос буюу нийт 5470 тн тоосжилт үүсэх боломжтойгоос 2034 тн  $pm_{10}$ , 232.9 тн  $pm_{2.5}$  тоос агаарт дэгдэхээр байна. Тоосонцор тархалтын хувьд уурхайгаас 10 км хүртэлх зайд, бусад чиглэлд 4 км хүртэлх зайд тоосжилтын нөлөөлөл үүсэхээр байна,
- Уурхайн үйл ажиллагаанд ашиглах тээврийн хэрэгслүүдээс 11.1 тн CO, 29.0 тн NOx, 1.93 тн  $PM_{10}$ , 0.021 тн SO<sub>2</sub>, 1.55 тн VOCs ялгарж уурхайн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй бүсээс 1 км хүртлэх тойрогт азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 25-220 мкг/м<sup>3</sup> хэмжээгээр ажиглагдах боломжтой байна,
- Алтны шороон ордын төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд тэсэлгээ хийх, шимт хөрс болон үндсэн хөрс хуулах, элс олборлох, ачих, буулгах, тээвэрлэх үйл ажиллагаанаас хамгийн их сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

### 3.3. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Уурхайн ашиглалтын явцад элс угаан баяжуулахад 79320 м<sup>3</sup>/жил, ажилчдын унд, ахуйн хэрэглээнд 558 м<sup>3</sup>/жил, замын тоосжилт дарахад 3000 м<sup>3</sup>/жил ус ашиглан гүний усны нөөцийг бууруулна,
- Уурхайд шүүрлийн ус орж ирэх бөгөөд үүнийг шавхан зайлуулах замаар газрын доорх усны нөөцийг бууруулах,
- Хүчтэй аадар бороо, үерийн үед уурхайн бохир ус, тунаах нуурын ус хальж хөрсөөр дамжин гүний усыг бохирдуулах.
- Хөрс хуулалт болон элс олборлох ажлын үед хөрсний шүүрлийн ус орж ирэх бөгөөд шүүрлийн усыг насосоор шавхан авч уурхайн тоосжилт дарах ажилд ашиглах замаар гүний усны нөөцийг бууруулна.

### 3.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Төслийн хугацаанд 10.48 сая.м<sup>3</sup> уулын цулыг хөндлөн газрын хэвлийг эвдрэлд оруулах, 73 га талбай газрын гадарга, хөрсөн бүрхэвч эвдрэх, дарагдах, ургамлан нөмрөг шимт хөрстэй хуулагдан устах нөлөөлөлд өртөхөөр байна,
- Хүнд оврын машин техникийн засварын газраас ШТМ асгарч хөрсийг их бага хэмжээгээр бохирдуулах,
- Уурхайн ажилчид олон салаа зам гарган тээвэрлэлт хийсэнээс эрүүл газрын хөрсийг элэгдэл эвдрэлд оруулах,
- Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг ил задгай хаях, шингэн бохирдол хөрсөнд нэвчих зэргээр хөрсийг бохирдуулах.
- Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл их байх бөгөөд нөлөөлөлд өртөх объект нь уулын ажилд өртөх талбай, элс угаан баяжуулах цехийн үйл ажиллагаанд өртөх талбай, дэд бүтцийн байгууламжуудад өртөх талбайн хөрсөн бүрхэвч хамаарна. Үүнээс гадна хатуу болон шингэн хог хаягдлын ил задгай хаях, ШТМ газрын гадаргад алдах зэргээс хөрсөн бүрхэвчийг бохирдуулах, олон салаа зам гарган талхагдалд оруулах зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй юм.

### 3.5. Ургамлан нөмрөг

- Уурхайлалтанд өртөх талбай болон гадаад, дотоод тээврийн талбайн ургамлан нөмрөг шимт хөрстэй хамт хуулагдан устгах,
- Төслийн бүхий л шатны үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн их байна. Үүнээс гадна хатуу шингэн хог хаягдлыг ил задгай хаях, олон салаа зам гаргах, тоосжилт ихээр үүсгэх, уурхайн тухайн жилийн төлөвлөлтийн хэмжээнээс хэтрүүлэн газар хөндөх зэргээр ургамлан нөмрөгийг талхагдалд оруулах, тоосжилтын нөлөөгөөр ургамлын фотосинтезийн эрчмийг бууруулах сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй юм.

### 3.6. Амьтан

Төслийн талбайд гаргасан нүх, ухаш зэрэгт мал амьтан унаж бэртэх, үрэгдэх. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх шууд сөрөг нөлөөлөл бага бөгөөд төслийг хүчин чадлаас хэтрүүлэн ажиллах, ажилчид хулгайн ан хийх, их хэмжээний давтамж бүхий дуу чимээ үүсгэх, уурхайн ухаш, хиймэл нуур зэрэгт хаалт хашилт хийгээгүйн улмаас мал, амьтан унаж бэртэх зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй.

### 3.7. Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Төслийг хэрэгжүүлэхэд ажилчдыг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах нь оршин суугчдын амьжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөтэй,
- Мөн үйл ажиллагааны явцад техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс эсвэл гэнэтийн аюул осол гарснаас улбаалан ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг нийгэм эдийн засгийн олон сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай,
- Уурхайн ажлын үед ашиглаж буй техник, машин механизмаас дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн ам, ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ,
- Орон нутгийн оршин суугчдын эдийн засгийн үзүүлэлтүүд, бэлчээрийн доройтол, малын тарга хүч буурах зэрэг нөлөөллүүд үүсэх болно.

## ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОМТ, ОХШХ-ийг боловсруулав.

**Зорилго:** “ЭЙЧ ЭС ЭЙЧ ЭС” ХХК-ийн “Хадат толгойн хойд үргэлжлэл дэх алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө оршино.

“Хадат толгойн хойд үргэлжлэл дэх алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 13,078.0 мян.төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг 2023 онд техникийн нөхөн сэргээлтийг гадаад болон дотоод овоолгоор гүйцэтгэнэ, харин биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 2024 оноос эхлэн хийж гүйцэтгэхээр тусгагдсан байна.

### **Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:**

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, гүний усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- Байгаль орчныг хамгаалахад хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно,
- БОМТ-ий дагуу үйл ажиллагаа явуулахад дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдийг тодорхойлох,
- Мэргэжлийн байгаль орчны ажилтантай байх,
- БОМТ-ий тайлан болон БОМТ-ний хэрэгжилтийг цаг тухай бүрт холбогдох байгууллагуудад хүргүүлэх, тайлагнах, хүлээлгэн өгөх шаардлагатай.



### **Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө**

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан. Хуулин дээрх шаардлагын дагуу Хадатын толгойн хойд үргэлжлэл дэх алтны шороон ордын төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

**ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

*Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг / 2023 он/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Агаарын орчин</b>									
